



2025 ОНЫ

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2025 ОНЫ 6 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР

АГУУЛГА

01. БИДНИЙ ТУХАЙ

- Компанийн товч танилцуулга
- Бидний түүх
- 2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

03. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Засаглалын үйл ажиллагааны тайлан
- Гүйцэтгэх удирдлага
- Хувьцааны мэдээлэл
- Хөрөнгө оруулагчидтай харилцах үйл ажиллагаа
- Ногдол ашиг
- Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл эзлэлт
- QPAC- н тоон үзүүлэлтүүд
- Онцлох санхүүгийн үзүүлэлтүүд
- IPO хийх үеийн төсөөлөл ба гүйцэтгэл
- Мэдээлэл технологийн үйл ажиллагааны онцлох ажлууд

04. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД- СУГ

- Санхүү байдлын тайлан
- Орлогын тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан



БИДНИЙ ТУХАЙ

- Компанийн товч танилцуулга
- Бидний түүх
- 2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд




ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн тухай


Инновэйшн Инвестмент ХК нь 2017 оноос хойш технологийн хурдацтай хөгжилд тулгуурлан иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягийг хялбаршуулах зорилго бүхий санхүү, төлбөр тооцоо, мэдээлэл технологийн чиглэлээр шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт менежментийн чиглэлээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2023 оны 12 дугаар сард олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон. Инновэйшн Инвестмент ХК-ийн хөгжүүлсэн QPay үйлчилгээ нь Монгол улсад хамгийн өргөн хэрэглээтэй дотооддоо хөгжүүлсэн төлбөр тооцооны системд зүй ёсоор тооцогддог.

Групп компани




Инновэйшн Инвестмент ХК нь группийн хэмжээнд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, тэлэлтийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг ба QPay үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “KKTT” ХХК, Мерчантуудад чиглэсэн үйлчилгээнүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах “Дижитал Мерчант Сервисэс” ХХК гэх хоёр охин компанитай үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн бүтэц



Компанийн хүний нөөц



Компанийн хэрэглэгчдийн бааз



БИДНИЙ ТҮҮХ

2016

Хаан банканд анхны нэвтрүүлэлт хийгдэхээр тохиролцож QR код уншуулан гүйлгээ хийх анхны хөгжүүлэлт хийгдэв.

2017

Анхны хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхээр группийн толгой компанийг буюу “Инновэйшн Инвестмент” ХК-ийг үүсгэн байгуулав.

2018

Анхны хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэхээр группийн толгой компанийг буюу “Инновэйшн Инвестмент” ХК-ийг үүсгэн байгуулав.

2019

Pos/кассын систем хөгжүүлэлт буюу Хэрэглэгчийн систем нийлүүлэгч компаниудад зориулан шинэчилсэн шинэ POS API хөгжүүлж нэвтрүүлэв.

2023

Технологийн салбарын анхны IPO-г амжилттай хийлээ.

2022

Дэлхийн 64 улсад нэвтэрсэн БНХАУ-ын хамгийн өргөн хэрэглээтэй цахим төлбөрийн систем болох олон улсын WechatPay үйлчилгээтэй экосистемийн гэрээ байгуулж Монгол улсдаа анхлан нэвтрүүлэв.

2021

Олон улсын картын Unionpay үйлчилгээтэй хамтын ажиллагааг эхлүүлж картын системд холбогдов.

2020

QR нэхэмжлэх үүсгэх мерчантын шинэ API version 2.0 хувилбарыг нэвтрүүлэв.

2024

Ази, европын 24 улсад нэвтэрсэн БНСУ-ын №1 цахим төлбөрийн систем болох GLN International-тэй хамтран БНСУ-ын жуулчид эх орондоо хэрэглэдэг төлбөрийн апп-аараа Монголд QR Pay QR кодыг уншуулан төлбөрөө шууд хийх үйлчилгээг нэвтрүүлэв.

2024

IPO хийснээс хойш 1 жилийн дотор ангилал ахиж МХБ-ийн II ангилалд арилжаалагдаж эхлэв.

2025

Монголын хөрөнгийн биржийн **ТОП 20** индексийн багцад шинээр нэмэгдлээ.

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



**МХБ-ийн ТОП 20
индексэд нэмэгдэж
орлоо**

“Инновэйшн инвестмент” ХК-ийн QPAУ симболтой үнэт цаас нь Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индексэд 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр нэмэгдэж орлоо



**Хувьцаа
эзэмшигчдэдээ ногдол
ашиг олгов**

2024 оны цэвэр ашгаас нийт 7.4 тэрбум төгрөгийг хуваарилсан бөгөөд үүнээс 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр ҮЦТХТ ХХК-аар дамжуулан тараасан.



**Ажилтны тоо 38%-аар
нэмэгдлээ**

2024 оны цэвэр ашгаас нийт 7.4 тэрбум төгрөгийг хуваарилсан бөгөөд үүнээс 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр ҮЦТХТ ХХК-аар дамжуулан тараасан.



**www.i-investment.mn
вэбсайт шинэчилж
хөрөнгө оруулагчдад
зориулсан цэстэй боллоо**

Инновэйшн Инвестмент ХК-ийн вэб сайтыг шинэчилж хөрөнгө оруулагчдад зориулсан IR(Investor relation) цэстэй боллоо. Ингэснээр хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, хөрөнгийн зах зээлийн оролцогчид компанийн үйл ажиллагаа болон хувьцаатай холбоотой мэдээллийг нэг дороос авах боломжтой юм.



**IBAN дансны
дугаарлалтруу
шилжив**

Монгол банкнаас гаргасан журмын дагуу арилжааны банкууд нь дансны дугаарлалтыг IBAN стандарт руу шилжүүлсэн тул түүнд нийцүүлэн бүх төрлийн гүйлгээг IBAN дугаарлалтаар хийх боломжийг бүрдүүлэв.



**QPAy QR-ийг
хүргэлтээр авах
боломжтой болов**

2025 оны 1 улирлаас эхлэн иргэн мерчант цахимаар гэрээ байгуулан QPAy хэвлэмэл QR-ийг хүргэлтээр авах боломжтой болов. Цаашлаад үе шаттайгаар цахим гэрээг нэвтрүүлж цаасны хэрэглээг бууруулж, бизнес эрхлэгчдэдээ хялбар үйлчилгээ үзүүлэх боломж бүрдээд байна.



**CRM, OMNICHANNEL
систем нэвтрүүллээ**

Харилцагчийн үйлчилгээний чанар стандартыг сайжруулах, харилцагчийн санал хүсэлтийг шийдвэрлэх хугацааг богиносгох үүднээс компанийн хэмжээнд нэгдсэн CRM, OMNICHANNEL системүүдийг нэвтрүүллээ.



**ISO 27001:2022
стандартын
баталгаажилтыг хангав**

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилтэд Франц улсын Афнор байгууллагын итгэмжлэлээр МонсертФ ХХК-аар ISO 27001:2022 стандартын магадлах аудитыг амжилттай хийлгэлээ.




БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Бэлэн бус төлбөр тооцооны зах зээл
- QPAY- н тоон үзүүлэлтүүд
- Онцлох санхүүгийн үзүүлэлтүүд
- IPO хийх үеийн төсөөлөл ба гүйцэтгэл
- Мэдээлэл технологийн үйл ажиллагааны онцлох ажлууд




БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛ

МУ-ын бэлэн бус гүйлгээний тоо, үнийн дүн



■ Гүйлгээний тоо /мян.ширхэг/
● Гүйлгээний дүн /тэрбум төгрөг/

QRau зах зээлд эзлэх хувь



■ Гүйлгээний тоо /зах зээл эзлэлт/
● Гүйлгээний дүн /зах зээл эзлэлт/

- 2025 оны 2 дугаар улирлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт бэлэн бус гүйлгээний тоо 626.7 сая ширхэгт хүрч өмнөх улирлаас 23.1%, үнийн дүнгийн хувьд 195.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 38.2% хувиар тус тус өсөх төлөвлөгөөтэй байна.
- QRau үйлчилгээгээр хийгдэж буй гүйлгээнүүд нь тогтмол өсч 2024 оны эцэст нийт бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 8.5 хувийг эзэлж байсан бол 2025 оны 1 дүгээр улиралд зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлсэний үр дүнд 10.2 хувьд хүрсэн.
- Бид 2025 оны 2 дугаар улиралд QRau үйлчилгээгээр 7.4 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 113.8 сая ширхэг гүйлгээг дамжуусан бөгөөд бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 10 хувийг эзлэх эзлэх төлөвтэй байна.


QPAY-Н ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

QPay-ийн тухай


QPay нь QR кодоор төлбөр хийх, апп доторх төлбөрийн шийдэл, вэб суурьтай төлбөрийн системд мэргэшсэн технологийн компани юм. Бид Монгол Улсын бүх арилжааны банкууд болон финтек компаниудтай төлбөрийн системээ холбосон бөгөөд бизнесүүд болон хэрэглэгчдэд хамгийн хялбар, найдвартай төлбөрийн шийдлийг санал болгож байна.



ГҮЙЛГЭЭНИЙ ТОО /мянган ширхэг/
Улирлын дундаж өсөлтийн хувь (2024Q1-2025Q2):
13.8%



ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН /тэрбум.төг/
Улирлын дундаж өсөлтийн хувь (2024Q1-2025Q2):
15.5%




2025 Q2 байдлаарх гүйлгээний үзүүлэлтүүд:

Өдрийн дундаж гүйлгээний тоо
628.6 мянган ширхэг



Сарын дундаж гүйлгээний тоо
18.9 мянган ширхэг



Улирлын нийт гүйлгээний тоо
113.8 сая ширхэг



Өдрийн дундаж гүйлгээний үнийн дүн
41.1 тэрбум төгрөг



Сарын дундаж гүйлгээний үнийн дүн
1,240.4 тэрбум төгрөг



Улирлын нийт гүйлгээний дүн
7.4 их наяд төгрөг



Нэгж гүйлгээний дундаж үнийн дүн
60,024₮

2025 оны 2-р улирал



ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Санхүүгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	2022	2023	2024	2024Q2	2025 Q2	Өөрчлөлт
БАЛАНС						
Нийт хөрөнгө	6.76	18.76	21.71	21.06	25.31	20.2%
Нийт өр төлбөр	0.59	1.32	6.43	3.15	2.44	-22.5%
Өөрийн хөрөнгө	6.17	17.45	15.28	17.9	22.87	27.8%
ОРЛОГЫН ТАЙЛАН						
Борлуулалтын орлого	6.34	13.24	26.23	10.95	16.45	50.2%
Борлуулалтын өртөг	1.12	6.04	12.05	4.47	6.78	51.7%
Нийт ашиг	5.22	7.2	14.18	6.48	9.68	49.4%
Цэвэр ашиг	3.43	5.7	10.03	5.28	7.32	38.6%

Харьцаа	2022	2023	2024	2024Q2	2025 Q2
Ашигт ажиллагаа					
Нийт ашгийн маржин	82.3%	54.4%	82.3%	59.2%	58.8%
Үйл ажиллагааны ашгийн ахиуц	61.1%	48.2%	61.1%	58.3%	49.7%
Цэвэр ашгийн маржин	54.0%	43.0%	54.0%	48.2%	44.5%
Өөрийн хөрөнгийн өгөөж	77.3%	48.2%	77.3%	39.3%	35.9%
Нийт хөрөнгийн өгөөж	68.6%	44.6%	68.6%	33.3%	31.6%
Хөрвөх чадвар					
Эргэлтийн харьцаа	11.8	14	2.9	6.1	16
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	4.8	12.1	2.7	5.3	13.8
Төлбөрийн чадвар					
Өрийн харьцаа	8.7%	7.0%	29.6%	15.0%	9.6%
Өр ба эздийн өмчийн харьцаа	9.5%	7.5%	42.1%	17.6%	10.7%

- Компанийн нийт хөрөнгө 2022–2024 оны хооронд жил бүр дунджаар 101%-иар өссөн бол 2025 оны хагас жилээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад **20%-ийн өсөлттэй** байна.
- Харин компанийн цэвэр ашиг 2022–2024 оны хугацаанд жил бүр дунджаар 140%-иар өссөн бөгөөд 2025 оны хагас жилээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад **49.4%-иар өссөн** байна.


ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (2025Q2)

НИЙТ ХӨРӨНГӨ БОЛОН ROA




- 2025 оны хагас жилийн байдлаар нийт хөрөнгө 25.3 тэрбум төгрөг, нийт хөрөнгийн өгөөж 31.6% байгаа бөгөөд жилд шилжүүлэн тооцвол 63.2 хувийн нийт хөрөнгийн өгөөжтэй байна.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БОЛОН ROE



- 2025 оны хагас жилийн байдлаар өөрийн хөрөнгө 22.9 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 35.9% байгаа ба жилээр тооцвол 71.8 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй байна.

ЦЭВЭР АШИГ БОЛОН ЦЭВЭР АШГИЙН МАРЖИН



- 2025 оны хагас жилийн байдлаар цэвэр ашиг 7.3 тэрбум төгрөг байгаа бол цэвэр ашгийн маржин 44.5% байна.


БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН ӨРТӨГ



- 2025 оны хагас жилийн байдлаар борлуулалтын орлого 16.5 тэрбум төгрөгт хүрсэн ба борлуулалтын өртөг 6.78 тэрбум төгрөг байна.

IPO ХИЙХ ҮЕИЙН ТӨСӨӨЛӨЛ БА ГҮЙЦЭТГЭЛ /2024-2025Q2/

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (тэрбум төгрөг)




БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
145%

БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
147%

- 2025 оны хагас жилээр борлуулалтын орлого 16.45 тэрбум төгрөгт хүрснээр IPO хийх үеийн төсөөллийг 147%-иар биелүүллээ.

ЦЭВЭР АШИГ (тэрбум төгрөг)




БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
128%

БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
124%

- Мөн цэвэр ашиг 7.32 тэрбум төгрөгт хүрснээр IPO хийх үеийн төсөөллийг 128%-иар биелүүллээ.

НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ (ROA)%




БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
93%

БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
106%

- Харин нийт хөрөнгийн өгөөж 31.6% хүрснээр IPO хийх үеийн төсөөллийг 106%-иар биелүүллээ.

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ (ROE)%



БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
110%

БИЕЛЭЛТИЙН ХУВЬ
115%

- 2025 оны хагас жилээр өөрийн хөрөнгийн өгөөж 35.9% байгаа нь IPO хийх үеийн төсөөллийг 115%-иар биелүүлсэн байна.

IPO ХИЙХ ҮЕИЙН ТӨСӨӨЛӨЛ

ГҮЙЦЭТГЭЛ

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

KATALON (Enterprise) системийг нэвтрүүлэв

Компанийн хэмжээнд хийгддэг бүхий л хөгжүүлэлт, системийн тестийг гар аргаар хийдэг байсныг автоматжуулж Katalon (Enterprise) системийг бүрэн нэвтрүүллээ. Ингэснээр системийн тестэд зарцуулдаг хугацааг 30-60 дахин багасгаж, бүтээмжийг нэмэгдүүлэв.

Apache JMeter системийг бүрэн нэвтрүүлэв

Apache Jmeter систем нэвтрүүлснээр системийн ачааллын хэмжилтийг богино хугацаанд тогтмол хийж, өгөгдлийн сангийн системийн үйл ажиллагааг тогтмол хэмжиж чаддаг болсон. Гарсан үр дүнд тулгуурлан системийн ачаалал даах чадварыг тогтмол сайжруулж, систем, үйл ажиллагаа доголдох эрсдлийг буурууллаа.

POSTMAN платформуыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэв

Компанийн хэмжээнд системүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах, чанарын тест хийх зориулалттай POSTMAN платформуыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүллээ. Ингэснээр системүүдийн алдааг богино хугацаанд нарийвчлан шалгаж, тухай бүрд нь цаг алдалгүй арга хэмжээ аван ажиллаж байна.

Аудит ба эрсдлийн үнэлгээнд тулгуурлан МАБ журам шинэчиллээ

МАБМТ-ны хэрэгжилтийг тасралтгүй хангах зорилгоор Дотоод аудит, Эрсдэлийн үнэлгээг компанийн хэмжээнд тус тус хийж, үр дүнд үндэслэн бизнес зорилттой уялдуулж МАБ-ын бодлого журам болон холбогдох бичиг баримтуудыг шинэчлэн баталлаа.

Техникийн эмзэг байдлын үнэлгээ хийж гүйцэтгэв

БНЭУ-ын SISA байгууллагатай хамтран техникийн эмзэг байдлын үнэлгээг төлөвлөгөөний дагуу 2025 оны I хагас жилд 2 удаа хийж гүйцэтгэв.

НPE dHCI шинэ дэд бүтэц

2024 оны 9 сард худалдан авсан НPE dHCI суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжид Qraу төлбөрийн системийн үндсэн орчныг бүрэн шилжүүлж дуусгав. Үндсэн орчныг тасалдал, зогсолт хамгийн багатайгаар шилжүүлсэн бөгөөд шинэ дэд бүтэц рүү шилжүүлснээр хурд гүйцэтгэл сайжирч, нөөц ашиглалт нэмэгдэн, системийн тогтвортой ажиллагаа хангагдав.

EBarimt 3.0 системийг хэрэглээнд нэвтрүүлэв

Одоогийн ашиглаж буй ebarimt 2.0 системийг сайжруулж ebarimt 3.0 системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Ebarimt 2.0 дээр алдаа заагаад баримт үүсэхгүй байх асуудлууд гардаг байсан нь EBarimt 3.0 нэвтэрснээр энэхүү асуудал шийдэгдэж хэрэглэгчид илүү найдвартай баримтаа үүсгүүлэн авах боломжтой болов.


Нөөц дата төвийн байршлыг өөрчлөв

Байгалийн гамшигт үзэгдлээс тодорхой түвшинд сэргийлэх үүднээс Нөөц дата төвийг Үндсэн дата төвөөс зайны хувьд холдуулах арга хэмжээг хэрэгжүүлэв. Тухайн суурь дэд бүтцийг шинээр зохион байгуулж өгөгдлийн сангуудыг бодит цагийн горимоор хуулбарлан хадгалж байна. Qraу төлбөрийн систем бүхэлдээ эсвэл бүрдэл хэсгүүд эрсдлийн үед нөөц дата төв рүү шилжин ажиллах боломжийг 2025 оны III, IV улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөл
- Засаглалын үйл ажиллагааны тайлан
- Гүйцэтгэх удирдлагын баг
- Хөрөнгө оруулагчидтай харилцах үйл ажиллагаа
- Хувьцааны арилжааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээлэл
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



- Ай Си Ти Групп ХК
- Эн Си Ди Групп ХХК
- Шагдарсүрэн Энхбаяр
- Юнимедиа Солюшнс ХХК
- Могоул ХХК
- ККТТ ХХК
- Айкор Партнерс ХХК
- Рентракс ХК
- Бусад

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2,045 хувьцаа эзэмшигчтэй байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулагдлаа. Хурлаар компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах, ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөж олгох болон компанийн хаяг өөрчлөгдсөнтэй холбоотой компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлуудыг баталж шийдвэр гаргасан бөгөөд 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ –ийн тогтоолыг танилцуулсан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ТУЗ-ИЙН ДАРГА
А.БАТТАМИР

Мэдээлэл технологийн салбарт
18 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Б. НАНДИН-ЭРДЭНЭ

Санхүү эдийн засгийн их сургуулийн
багш, Боловсролын салбарт
22 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Т.ДАШЦЭРЭН

Мэдээлэл технологийн салбарт
12 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Ш. УЯНГА

Татвар, санхүүгийн салбарт
20 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Б.АНХБОЛД

Мэдээлэл технологийн салбарт
12 жил ажилласан туршлагатай




ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Г.ХАТАНБОЛД

Хөрөнгө оруулалт, менежмент,
мэдээлэл технологийн салбарт 20 жил
ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Б.ЧУЛУУНСҮХ

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-
ийн үүсгэн байгуулагч, Мэдээлэл
технологийн салбарт 16 жил
ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
У.НАРАНБААТАР

Банк, санхүү, мэдээлэл технологийн
салбарт 20 жил ажилласан
туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
У.МӨНХЗУЛ

Үл хөдлөх барилга угсралтын
салбарт 8 жил ажилласан
туршлагатай



ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
О.МАРАЛМАА

Компанийн засаглал, үйл
ажиллагааны чиглэлээр 9 жил
ажилласан ажлын туршлагатай


ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны 05 дугаар сарын -27ны өдөр “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Тус журамд ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

ТУЗ нь 2025 онд биечлэн, цахимаар, биечлэн болон цахим хосолсон хэлбэрээр 100% ирцтэй 13 удаа, 85.71% дээш хувийн ирцтэй 4 удаа, нийт 17 удаа хуралдаж, 41 тогтоол шийдвэр гаргасан.



ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд 4 хороод ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 8 удаа хуралдаж хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Худалдсан тоо
1	Аудитын хороо	1 удаа
2	Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо	5 удаа
3	Эрсдэлийн удирдлагын хороо	1 удаа
4	Стратеги хөгжлийн хороо	1 удаа

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Г.ЭРДЭНЭМӨНХ

CEO

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Б.ЭНХБОЛД

CFO

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байгаа.



Д.ЖАНЧИВ

СТО

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Технологи хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



С.ГҮРЖАВ

“ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС” ХХК

2019 оноос “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.



О.ХОНГОР

CBO

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



Ц.ГОМБОДОРЖ

CIO

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирлаар ажиллаж байгаа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



CMM-С INVESTOR RELATIONS ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ АВЧ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА.

Хөрөнгө оруулагчидтайгаа үр дүнтэй харилцах, итгэлцлийг бий болгох, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор Хөрөнгө оруулагчдын харилцааны (IR) зөвлөх үйлчилгээг Capital Markets Mongolia /CMM/-с авч хамтран ажиллаж байна.

[MSE: QPAY]
“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
IR CALENDAR-ЫГ ЗАРЛАЖ БАЙНА

4-Р CAP		5-Р CAP	
4/08	ХЭХ-ЫН БҮРТГЭЛИЙН ӨДӨР	5/26	ANALYST DAY
4/21	НОГОЛ АШИГ ТАРААХ ӨДӨР	6/02	ШИШЭЭГДСЭН ЭЗЭМШИГЧИЙН ХУРАЛ
4/28	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ	7/20	ХАГАС ЖИЛИЙН САХУУГИЙН ТАЙЛАН
4/30	ЖИЛИЙН САХУУГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН НИЙЛЭХ ӨДӨР	8/06	EARNINGS CALL ЗОХИОН БАЙГУУЛАА

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН IR CALENDAR -Г ЗАРЛАСАН.

Хөрөнгө оруулагчдад зориулан 2025 оны эхний хагас жилийн IR Calendar-ийг зарласан бөгөөд энэхүү календарь нь хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлж болох үйл явдлуудын огноог хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлэх зорилготой.



CEO LETTER


Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэдээ хүргэх захидлаар 2024 оны гүйцэтгэлээ үнэлж, цаашдын өсөлт, амжилтыг тодорхойлж, дунд хугацааны төлөвлөгөө, зорилтуудаа хуваалцсан.



“ANALYST DAY” АРГА ХЭМЖЭЭ

Үнэт цаасны компаниудын мэргэжлийн шинжээчдийг оролцуулсан “Analyst day” арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа.

[MSE:QRAY] ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ (2025 2 УЛИРАЛ)



EPS
харьцаа

39.6

P/BV
харьцаа

1.74

P/E
харьцаа

5.44

ДЭЭД
ХАНШ

227.99

ДУНДАЖ
ХАНШ

215.11

ДООД
ХАНШ

178.00

Өдрийн дундаж арилжаа

Хувьцааны тоо:
41.4 мян.ш

Арилжааны дүн:
8.3 сая₮

Улирлын нийт арилжаа

Хувьцааны тоо:
5.2 сая.ш

Арилжааны дүн:
1.03 тэрбум₮

Багцын арилжаа

Арилжааны тоо:
2 удаа

Хувьцааны тоо:
28.9 сая.ш

Арилжааны дүн:
6.3 тэрбум₮

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

3.7 тэрбум төгрөг

2025/04/21-ний өдөр ногдол ашгийг ҮЦТХТ-өөр дамжуулан тараалаа.

2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 20 төгрөгийн ногдол ашиг олгохоор зарласан.

Шийдвэрийн огноо: ТУЗ-ийн 2025/02/07-ны өдрийн 05/30 тоот тогтоол

Ногдол ашгийн жилийн өгөөж:

18%

“Инновэйшн Инвестмент” ХК нь 2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд нийт **40₮** ногдол ашиг тарааж нийт **7.4 тэрбум төгрөг** хуваариллаа.

Инновэйшн Инвестмент ХК нь хувьцаагаа олон нийтэд санал болгож 2023.12.04-ний өдрөөс 2023.12.08-ны өдрийн хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Хөрөнгө оруулалтын зориулалт	Зарцуулахаар төлөвлөсөн 2023-2026 он		Зарцуулалт 2025Q2	
	/сая₮/	/хувиар/	/сая₮/	/хувиар/
Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	1,871.99	22.50%	139.93	1.68%
Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа	2,495.99	30.00%	0	0.00%
Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	1,247.99	15.00%	1,125.82	13.53%
“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	2,080.00	25.00%	2,080.00	25.00%
Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	623.99	7.50%	0	0.00%
НИЙТ	8,319.96	100 %	3,345.76	40.2%

Бид 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн **40.2%**-ийг зориулалтын дагуу зарцуулаад байгаа ба үлдсэн хөрөнгийг зориулалтын дагуу 2025 болон 2026 онуудад зарцуулахаар төлөвлөж байна.



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Санхүү байдлын тайлан
- Орлогын тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,726,232	21,421,972
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,985,144	3,884,674
НИЙТ ХӨРӨНГӨ	21,711,376	25,306,647
Өр төлбөр ба эздийн өмч		
Богино хугацаат өр төлбөр	6,359,884	1,338,773
Урт хугацаат өр төлбөр	71,575	1,100,639
НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,431,459	2,439,412
Эздийн өмчийн дүн	15,279,917	22,867,235
НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	21,711,376	25,306,647

ОРЛОГЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30
Борлуулалтын орлого	26,231,629	16,454,825
Өртөг	(12,051,045)	(6,776,764)
НИЙТ АШИГ/(АЛДАГДАЛ)	14,180,584	9,678,061
Борлуулалт, маркетингийн зардал	(805,563)	(646,653)
Ерөнхий удирдлагын зардал	(1,941,549)	(1,788,685)
Бусад орлого	(0)	102
Бусад зардал	(45,307)	(37,931)
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	11,388,165	7,204,894
Санхүүгийн орлого	1,677,294	997,479
Санхүүгийн зардал	(1,703)	(60,825)
Үндсэн хөрөнгө борлуулсаны олз	(3,622)	(6,043)
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал	(13,528)	47,185
ОРЛОГЫН ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ/(АЛДАГДАЛ)	13,046,606	8,182,688
Орлогын татварын зардал/(буцаалт)	(3,020,452)	(865,211)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ/(АЛДАГДАЛ)	10,026,154	7,317,477

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	НИЙТ
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,279,917
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	269,841
Залруулсан үлдэгдэл	15,549,758
Бусад дэлгэрэнгүй орлого	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-
Зарласан ногдол ашиг	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,317,477
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-
2025 ОНЫ 6-Р САРЫН 30-ААРХ ҮЛДЭГДЭЛ	22,867,235

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,794,941	5,284,703
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,634,037)	(541,444)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,510,084)	(3,371,215)
Валютын ханшийн зөрүү	2,959	47,084
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	653,778	1,419,127
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	13,999,820	14,653,598
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	14,653,598	16,072,726



ХОЛБОО БАРИХ:

WEBSITE: WWW.I-INVESTMENT.MN

УТАС: (+976) 7610-2211

ИМЭЙЛ: INFO@QPAY.MN

**ХАЯГ: МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ
ДҮҮРЭГ, 15-Р ХОРОО, ГАНДИГИЙН ГУДАМЖ, NM TOWER
ОФФИС, 8 ДАВХАР**

IR CONTACT:

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

НЭР: П.МӨНХТУЯА

УТАС: 88004829

ИМЭЙЛ: MUNKHTUYA.P@QPAY.MN

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Инновэйшн Инвестмент ХК УБ-ийн гэрчилгээний дугаар: 9007001023 Үнэт цаасны код: MN0QPAY05709 Утасны дугаар: 76102211
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мэдээлэл технологийн үйл ажиллагаа Программ хангамжийн үйлчилгээ
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	184,889,160 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Хөрөнгө оруулагчийн харилцаа хариуцсан менежер П.Мөнхтуяа Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Энхболд

1. Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргав/

	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30
		/мян.төг/	/мян.төг/
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,726,232	21,421,972
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,985,144	3,884,674
	Нийт хөрөнгө	21,711,376	25,306,647
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	6,359,884	1,338,773
	Урт хугацаат өр төлбөр	71,575	1,100,639
	Нийт өр төлбөр	6,431,459	2,439,412
	Эздийн өмчийн дүн	15,279,917	22,867,235
	Нийт өр төлбөр болон эздийн өмчийн дүн	21,711,376	25,306,647
Орлогын тайлан	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30
		/мян.төг/	/мян.төг/
	Борлуулалтын орлого	26,231,629	16,454,825
	Өртөг	(12,051,045)	(6,776,764)
	Нийт ашиг/(алдагдал)	14,180,584	9,678,061
	Борлуулалт, маркетингийн зардал	(805,563)	(646,653)
	Ерөнхий удирдлагын зардал	(1,941,549)	(1,788,685)
	Бусад орлого	(0)	102
	Бусад зардал	(45,307)	(37,931)
	Үндсэн үйл ажиллагааны үр дүн	11,388,165	7,204,894
Санхүүгийн орлого	1,677,294	997,479	
Санхүүгийн зардал	(1,703)	(60,825)	

		Үндсэн хөрөнгө борлуулсаны олз	(3,622)	(6,043)
		Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал	(13,528)	47,185
		Орлогын татварын өмнөх ашиг/(алдагдал)	13,046,606	8,182,688
		Орлогын татварын зардал/(буцаалт)	(3,020,452)	(865,211)
		Тайлант жилийн ашиг/(алдагдал)	10,026,154	7,317,477
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Нийт /мян.төг/	
		2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	15,279,917	
		Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	269,841	
		Залруулсан үлдэгдэл	15,549,758	
		Бусад дэлгэрэнгүй орлого	-	
		Өмчид гаргасан өөрчлөлт	-	
		Зарласан ногдол ашиг	-	
		Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,317,477	
		Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	
	2025 оны 6-р сарын 30-аарх үлдэгдэл	22,867,235		
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31 /мян.төг/	2025 оны 6-р сарын 30 /мян.төг/
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,794,941	5,284,703
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,634,037)	(541,444)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,510,084)	(3,371,215)
		Валютын ханшийн зөрүү	2,959	47,084
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	653,778	1,419,127
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,999,820	14,653,598
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,653,598	16,072,726
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт			
	Инновэйшн Инвестмент ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ болон өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тайлагнасан ба тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороонд хүргүүлсэн.			
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт			
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30
		Нийт ашгийн хувь	54%	59%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	43%	51%
		Цэвэр ашгийн хувь	38%	44%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	66%	37%
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	54.2	39.6
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Хөрвөх чадварын харьцаа	2024 оны 12-р сарын 31	2025 оны 6-р сарын 30
		Эргэлтийн харьцаа	2.94	16.0
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	2.94	13.8
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	42.1%	10.7%

3.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>2025 оны эхний хагас жилийн байдлаар QРау үйлчилгээ нь гүйлгээний тоогоор Монгол улсын хэмжээнд хийгдсэн нийт бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 10 хувийг эзлэх төлөвтэй байгаа ба гүйлгээний дүн нь 7.4 их наяд төгрөг байгаа нь нийт бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 2 хувийг эзлэх төлөвтэй байна. Бид QR төлбөр тооцооны салбартаа 90 гаруй хувийг дангаар хийж гүйцэтгэж байна. Олон улсын зах зээлд тэр дундаа Азийн бүс нутагт QRC төлбөр тооцоо нь эрчимтэй нэмэгдэж байгаа нь бидэнд төлбөр тооцооны зах зээлд тэлэлт хийх нөөц боломж байгааг харуулж байгаа юм.</p> <p>Төлбөр тооцооны зах зээлд байр сууриа бэхжүүлэх үүднээс 2025 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бүтээгдэхүүн хөгжүүлэлт, брэндинг, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөт ажлуудаас дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> • www.i-investment.mn вэб сайтыг шинээр угсарч IR цэстэй болсон. Ингэснээр хөрөнгө оруулагч, хувьцаа сонирхогч нар мэдээллийг нэг дор эмх цэгцтэй хүлээн авах боломж бүрдэж, хөрөнгө оруулагчийн харилцаа сайжирсан; • Мерчантад зориулсан Super App (Soft POS) бүтээгдэхүүний суурь судалгаа бүрэн хийгдэж, UI/UX ажил дууссан ба хөгжүүлэлтийн шатандаа явж байна; • Байгууллагын хэмжээнд CRM нэвтрүүлж, харилцагчийн бүх сувгийг нэгтгэн OMNICHANNEL болголоо. Ингэснээр харилцагчийн үйлчилгээний чанар сайжирч, илүү сайн, чанартай үйлчилгээг харилцагч мерчантууддаа хүргэх боломж бүрдлээ; • Мерчантийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх болон сайжруулах дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын суурь судалгаанууд хийгдэн, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.
3.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</p> <p>НББОУС, СТОУС, МУ-ын холбогдох хууль, тогтоомжийн дагуу батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.</p>
4.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл:</p> <ul style="list-style-type: none"> • 2025/06/06-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №06/49 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигч Могул ХХК-ийн охин компани болох Ай Ти Зон ХХК-иас дэд бүтцийн тоног төхөөрөмж 129,103,900 /нэг зуун хорин есөн сая нэг зуун гурван мянга есөн зуу/ төгрөгөөр худалдаж авах шийдвэр гаргасан. 	
5.	<p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийгэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</p>	
	<p>Инновэйшн Инвестмент ХК нь 2023.12.04-ний өдрөөс 2023.12.08-ны хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.</p> <p>2024 онд төлөвлөж байсны дагуу QРау төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр 1,125,826,606 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалт хийсэн бөгөөд үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу “Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа”-нд зориулагдах 1,247,994,608 төгрөгөөс зарцуулсан.</p> <p>Мөн 2024 оны 2 дугаар хагаст QРау үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой кампанит ажлыг явуулж байгаа ба тус үйл ажиллагаатай холбоотой 139,938,166 төгрөгийн зардал гарсан. Үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн “Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үйл ажиллагааны тэлэлт” хэсгээс зориулалтын дагуу зарцуулаад байна.</p>	

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан:

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Зарцуулахаар төлөвлөсөн		Зарцуулсан
		Эзлэх хувь	Мөнгөн дүн	Мөнгөн дүн
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	22.5%	1,871,991,911	139,938,166
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа	30.0%	2,495,989,215	0
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	15.0%	1,247,994,608	1,125,826,606
4	“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	25.0%	2,080,003,050	2,080,003,050
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	7.5%	623,985,266	0
	Нийт	100%	8,319,964,050	3,345,767,822

2023 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн. Тайлант жилд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 40.2%-ийг зориулалтын дагуу зарцуулаад байгаа ба үлдсэн хөрөнгийг зориулалтын дагуу 2025 болон 2026 онуудад зарцуулахаар төлөвлөж байна.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Төлөөлөн удирдах зөвлөл

2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрэмд нийцүүлэн ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосон бөгөөд Компанийн одоогийн ТУЗ нь дараах бүтэц бүрэлдэхүүнтэй байна.

№	Овог Нэр	Гишүүнчлэл	Ажлын туршлага
1	Адилбиш Баттамир	ТУЗ-ийн дарга	Мэдээлэл технологийн салбарт 18 жил ажилласан туршлагатай
2	Уртнасан Наранбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн	Банк, санхүү, мэдээлэл технологийн салбарт 20 жил ажилласан туршлагатай
3	Уламбаяр Мөнхзул	ТУЗ-ийн ердийн гишүүн	Үл хөдлөх барилга угсралтын салбарт 8 жил ажилласан туршлагатай
4	Гантулга Хатанболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	Хөрөнгө оруулалт, менежмент, мэдээлэл технологийн салбарт 20 жил ажилласан туршлагатай
5	Батзориг Чулуунсүх	ТУЗ-ийн ердийн гишүүн	Иновэйшн инвестмент ХК-ийн үүсгэн байгуулагч, Мэдээлэл технологийн салбарт 16 жил ажилласан туршлагатай
6	Баянмөнх Анхболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	Мэдээлэл технологийн салбарт 12 жил ажилласан туршлагатай
7	Шаравхорол Уянга	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Татвар, санхүүгийн салбарт 20 жил ажилласан туршлагатай
8	Тэрбиш Дашцэрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Мэдээлэл технологийн салбарт 12 жил ажилласан туршлагатай
9	Банзрагч Нандин-Эрдэнэ	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Санхүү эдийн засгийн их сургуулийн багш, Боловсролын салбарт 22 жил ажилласан туршлагатай. 2025 оны 06 дугаар сараас эхлэн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилогдсон.
10	Оюун Маралмаа	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Компанийн засаглал, үйл ажиллагааны чиглэлээр 9 жил ажилласан ажлын туршлагатай, 2025 оны 06 дугаар сараас эхлэн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдсон.

Гүйцэтгэх удирдлага

Компанийн дүрмийн 12 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм, Компанийн засаглал болон бүтэц зохион

байгуулалтын баримт, ТУЗ-гэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тус тусын харьяалах асуудлуудыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий удирдах түвшний албан тушаалтнууд ажилладаг.

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн хурал:

"Инновэйшн инвестмент" ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр цахим хэлбэрээр 77.58% хувийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулсан. Тус хурлаар компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах, ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах, нөхөж олгох болон компанийн хаяг өөрчлөгдсөнтэй холбоотой компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлуудыг баталж шийдвэр гаргасан бөгөөд 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/30 тоот ТУЗ-ийн тогтоолыг танилцуулсан.

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа: 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хувьцаат компанийн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь сар бүр хуралдаж, эрх үүргийнхээ хүрээнд холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна

ТУЗ-ийн ажлын товч тайлан: ТУЗ нь 2025 оны эхний хагаст биечлэн, цахимаар болон хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 17 удаа, 85.71% ба түүнээс дээш хувийн ирцтэй хуралдаж, 41 тогтоол шийдвэр гаргасан. 2025 оны эхний хагаст Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо 5 удаа, Аудитын хороо 1 удаа хуралдаж, Эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа хуралдаж, Стратеги хөгжлийн хороо 1 удаа хуралдаж, хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.

ТУЗ-ийн дэргэдэх хороод: ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод ажиллаж байгаа ба 2025 оны эхний хагас жилд нийт 8 удаа хуралдаж хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан. Үүнд:

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Хуралдсан тоо	Хорооны гишүүд
1	Аудитын хороо	1 удаа	<ul style="list-style-type: none"> Ш.Уянга (Хараат бус гишүүн) Т.Дашцэрэн (Хараат бус гишүүн) Г.Хатанболд
2	Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо	5 удаа	<ul style="list-style-type: none"> У.Наранбаатар Б.Нандин-Эрдэнэ (Хараат бус гишүүн) Т.Дашцэрэн (Хараат бус гишүүн)
3	Эрсдэлийн удирдлагын хороо	1 удаа	<ul style="list-style-type: none"> Ш.Уянга (Хараат бус гишүүн) Б.Нандин-Эрдэнэ (Хараат бус гишүүн) У.Мөнхзул
4	Стратеги хөгжлийн хороо	1 удаа	<ul style="list-style-type: none"> Б. Чулуунсүх Г.Хатанболд У.Наранбаатар Б.Анхболд А.Баттамир (ТУЗ-ийн дарга) Т.Дашцэрэн (Хараат бус гишүүн)

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт:

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний загварын дагуу компани өөрийгөө 2025 оны эхний хагаст дараах байдлаар үнэлсэн болно.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%

5	Эрсдэлийн удирдлага	8	7	88%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5	83%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	88%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
	Нэгдсэн дүн	72	69	96%

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Энхболд

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

2025.07.09



Мэдээлэл бэлтгэсэн, хянасан этгээдийн гарын үсэг, огноо:

Бэлтгэсэн:

Овог, нэр: П.Мөнхтуяа

Албан тушаал: Хөрөнгө оруулагчийн харилцаа хариуцсан менежер

Гарын үсэг:

2025.07.09